**МОНГОЛ УЛСЫН**
**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

# МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

*/Шинэчилсэн 4 дэх хэвлэл/*

УЛААНБААТАР ХОТ
2018 он

# МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА


**Боловсруулсан:**

Ц.БААСАНДЭЛГЭР — АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ажилтан, комиссар

**Хянасан:**

Х.ХАШБААТАР — АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар

Л.СҮХ-ОЧИР — АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн ХША-ны дарга, ахлах комиссар

Ц.ЦЭЦЭГДЭЛГЭРЭХ — АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн МБДША-ны дарга, ахлах комиссар

**Манай хаяг:**

210644 Улаанбаатар,
Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж - 41
Монгол Улсын Авлигатай тэмцэх газар
Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс

**Харилцах утас:**

70112468, 70112469, 70112499, 70112484
70112485, 70112427, 70110252, 70112452



Хэвлэлийн хуудас: 2.1 хх
Хэвлэсэн газар: “УРАНГАР ПРЕСС” ХХК

# ГАРЧИГ

1. Мэдүүлэг гаргагчийн тухай ойлголт ................................4
2. Мэдүүлэг гаргах харьяалал ..............................................5
3. Мэдүүлэг гаргагчийн үүрэг ...............................................8
4. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах ................................11
5. Хариуцлага хүлээлгэх үндэслэл ......................................13
6. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогыг мэдүүлэх тухай.........................................................................15
*А. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах тухай...............................15*
*Б. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж, баталгааны маягтаар бүртгүүлэх тухай /Загвар жишээ №1/.......................................................18*
7. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг гаргах */Загвар жишээ №2/* ....................................................43
8. Ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх асуудлаар мэдэгдэл, тайлбар гаргах */Загвар жишээ №3, №4/*.....................50
9. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай. 2017.04.13..........................................................60
10. “Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалт шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017.12.06-ны өдрийн 326 дугаар тогтоол........................................................................63

# НЭГ. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу дор дурдсан этгээд хуулийн үйлчлэлд хамаарна.

4.1.1.төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

4.1.2.төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;

4.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;

4.1.4.олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;

4.1.5.улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

4.1.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;

4.1.7.бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;

4.1.8.эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.

4.1.9.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.

## ХОЁР. МЭДҮҮЛЭГ ГАРГАХ ХАРЬЯАЛАЛ

Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 2 дахь хэсэгт тус тус заасны дагуу

***Авлигатай тэмцэх газарт:*** Авлигын эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.1-д заасан албан тушаалтан;

***Шүүхийн ерөнхий зөвлөлд:*** Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч;

***Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд:*** Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;

***Улсын Их Хурлын Тамгын газарт:*** Төрийн улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийнх нь хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх;

***Засгийн газрын хэрэг эрхлэх газарт:*** Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;

***Сангийн яаманд /хуучнаар Төрийн өмчийн хороо/:*** Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, банк, санхүүгийн байгууллага, биржийн удирдах албан тушаалтан, Монгол

Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан; /эдгээр хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/.

***Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанд:*** Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, ажлын албаны ажилтан, Засаг дарга, Засаг даргын орлогч;

***Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт:*** Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргаас томилогддог төрийн захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн захирал;

***Мэдүүлэг гаргагчийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд:***

1. Хуулийн үйлчлэлд хамрагдах нийтийн албан тушаалтан болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах албан тушаалын жагсаалтад орсон албан тушаалтан, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалтад дурдагдсан албан тушаалтан;
2. Төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албаны дарга, захирал,

эрхлэгч, тэдгээртэй адилтгах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;

3. Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд /Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;
4. Эрдэм шинжилгээ, инноваци, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг эрдэм шинжилгээний байгууллагын удирдах албан тушаалтан түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
5. Яам, агентлагийн дэргэдэх өөрийгөө санхүүжүүлдэг салбар нэгжийн удирдах албан тушаалтан харьяа байгууллагын түүнийг томилсон, эсхүл удирдах эрх бүхий албан тушаалтанд;
6. Төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй гэрээ байгуулж, улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг түр буюу байнга гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан тухайн төсвийн захирагчид /ерөнхий менежерт/;
7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигч Сонгуулийн ерөнхий хороонд, орон нутгийн сонгууль /аймаг, нийслэл, сум, дүүрэг/-д нэр дэвшигч нь тухайн орон нутгийн сонгуулийн хороонд.

## ГУРАВ. МЭДҮҮЛЭГ ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

***Хуульд заасан хугацаанд гаргаж өгөх***

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т зааснаар мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байх хугацаандаа жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргаж холбогдох байгууллага, албан тушаалтанд өгөх үүрэгтэй.

Дээр дурдсан хугацаанд мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэгт тус тус зааснаар гаргаж өгөөгүйд тооцно.



Мэдүүлэг гаргагч нь хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /цаашид “ХАСХОМ” гэх/-ээ эрх бүхий албан тушаалтан /цаашид “ЭБАТ” гэх/-д хүлээлгэн өгөхдөө Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын $2.6^{1}$-д “Мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим сан *(https://meduuleg.iaac.mn)-д* мэдүүлгээ гаргасан бол үнэн, зөв мэдүүлсэн талаарх баталгааг тухайн байгууллагын мэдүүлгийг хүлээн авах эрх бүхий албан тушаалтанд гаргана.” гэж заасны дагуу “баталгааны маягт”-аар гаргаж, “ХАСХОМ хүлээн авсан тухай бүртгэл”-ийн дэвтэрт гарын үсгээ зурах үүрэгтэй.

### *Хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлтийн тухай мэдэгдэх*

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т зааснаар мэдүүлэг гаргагч энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд мэдүүлгээ мэдүүлсний дараа хөрөнгө, орлого нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх буюу түүнээс дээш хэмжээгээр өөрчлөгдсөн бол өөрчлөлт орсноос хойш 30 хоногийн дотор мэдүүлж бүртгүүлнэ.

Их хэмжээний өөрчлөлтийг цахимаар мэдүүлэхдээ “мэдүүлэг гаргах үндэслэл”-ийг сонгож зөвхөн өөрчлөлт орсон хөрөнгө, орлогыг мэдүүлнэ. Тодруулбал, “Хөрөнгө, орлогод орсон их хэмжээ” гэдэгт Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны хамтарсан шийдвэрийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 240000 төгрөг болсон нь 60 сая төгрөг түүнээс дээшхи хэмжээг ойлгоно.

***Бодитой, үнэн зөв мэдүүлэх***

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-т зааснаар мэдүүлэг гаргагч нь өөрийн хувийн ашиг сонирхол, түүнчлэн өөрийн болон гэр бүлийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй.

***Хөрөнгө, орлогын эх үүсвэрийн талаар болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг тодорхой тайлбарлах***

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.8-д зааснаар мэдүүлэг гаргагч хөрөнгө, орлогын эх үүсвэрийг болон хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бодитой, үнэн зөв тайлбарлах үүрэгтэй. Хөрөнгө, орлого, зээлийг мэдүүлэхдээ УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 4 дэх хэсгийн 4.4 дэх хэсэгт заасныг баримтална.

***Батлагдсан маягтын дагуу засваргүй, тодорхой бичих, асуулт бүрд хариулах***

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 4 дэх хэсгийн 4.5 дахь хэсэгт зааснаар мэдүүлэг гаргагч мэдүүлгийг засваргүй, тодорхой, ойлгомжтой бичих бөгөөд асуулт бүрд хариулна.

# ДӨРӨВ. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ХЯНАН ШАЛГАХ

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах үндэслэлийг Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйл, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлд дараах байдлаар тогтоосон. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг иргэний өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо;
- Монгол Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний албан тушаалыг хавсарч байгаа бол тухайн гишүүний хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар;
- Авлигатай тэмцэх газрын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг өргөдөл, гомдолд үндэслэн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо;
- Бусад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газар тус тус хянан шалгана.

Авлигатай тэмцэх газар нь Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, 13.4, 13.5, 13.6 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.4, 26.5, 26.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу дараах үндэслэлээр хянан шалгана. Үүнд:

1. Мэдүүлгээ хуульд заасан хугацаанд нь гаргаж өгөөгүй;
2. Хөрөнгө, орлогын эх үүсвэрийг заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй;
3. Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг бүрэн гүйцэд гаргаагүй;
4. Өргөдөл, гомдол, мэдээллийн мөрөөр;
5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дагуу;
6. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг засваргүй, бүрэн гүйцэд бөглөгдсөн, хугацаандаа өгсөн эсэхэд хяналт тавьж, мэдүүлгийг зохих журмын дагуу гаргаж өгөхийг шаардах, хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байвал бүрэн эрхийнхээ хүрээнд хянан шалгах буюу Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах үүрэгтэй.

# ТАВ. ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ҮНДЭСЛЭЛ

1. Мэдүүлэг гаргагч ***Хөрөнгө, орлогын мэдүүлгээ*** хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй, худал мэдүүлсэн бол Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэгт заасны дагуу дараах хариуцлага хүлээлгэнэ. Үүнд:
   - Сануулах. Нэг сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хуулийн 10.4, 10.5-д заасан хугацаанаас хожимдуулсан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол;
   - Албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах. Зургаа хүртэл сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн, хөрөнгө, орлогын мэдүүлгээ удаа дараа хугацаа хожимдуулж гаргасан;
   - Албан тушаал бууруулах, эсхүл албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах. Зургаан сараас дээш нэг жил хүртэлх хугацааны цалин хөлстэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй буюу худал мэдүүлсэн бол;
   - Албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах. Нэг жилийн цалин хөлстэй тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан.
2. Мэдүүлэг гаргагч ***Хувийн ашиг сонирхлын мэдүүлгээ*** хугацаа хожимдуулж гаргасан, эсхүл бүртгүүлээгүй, худал мэдүүлсэн бол түүнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг

сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу дараах сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Үүнд:

- Хугацаанаас хожимдуулж гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол сануулах
- Удаа дараа хожимдуулж гаргасан бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан болон худал мэдүүлсэн бол албан тушаал бууруулах
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.3 дахь хэсэгт заасан хариуцлага хүлээлгэх зөрчлийг удаа дараа гаргасан болон гаргаж өгөөгүй бол нийтийн албанаас халах сахилгын шийтгэл тус тус ногдуулна.

3. Нийтийн албанд илтэд ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдсон этгээдийг нэр дэвшүүлж томилсон удирдах албан тушаалтныг дээд шатны албан тушаалтнаас албан тушаалыг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.
4. Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, эсхүл холбогдох материалыг Авлигын эсрэг хуулийн 10.3- т заасан хугацаанд ирүүлээгүй албан тушаалтныг эрх бүхий байгууллага, албан тушаалтан албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 30 хувиар бууруулах, уг зөрчлийг удаа дараа гаргасан бол албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулна.

# ЗУРГАА. ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫГ МЭДҮҮЛЭХ ТУХАЙ

Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогыг мэдүүлэхдээ Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журам”-ын 4 дэх хэсэгт заасныг тус тус баримтална. Үүнд:

**А. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах тухай**

4.1. Мэдүүлэгт дараах зүйлийг тусгана:

4.1.1. мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал;

4.1.2. хувийн ашиг сонирхлын байдал;

4.1.3. хөрөнгө, орлого.

4.2. Энэ журмын 4.1.1-д заасан “Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал” гэсэн хэсэгт хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй, эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичих бөгөөд Үүнд: гадаад улсад ажиллаж, сурч байгаа гэр бүлийн гишүүн хамаарна.

4.3. Энэ журмын 4.1.2-т заасан “Хувийн ашиг сонирхлын байдал” гэсэн хэсэгт дараах зүйлийг мэдүүлнэ:

4.3.1. “Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд” / Үүнд: Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү болон эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүгийн нэрийг түүний эцэг /эх/-ийн нэрийн хамт, ямар хамааралтай болох, ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал, бизнес, үйл ажиллагааны чиглэл, төрсөн газар, үндсэн харьяаг тус тус мэдүүлнэ/;

4.3.2. “Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд” /Үүнд: ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээд, тэдгээртэй ямар харилцаа, хамааралтай /байсан/ болох, үйл ажиллагааны чиглэл, зорилго, байгууллага, ажил, албан тушаал эрхэлж байгаа /байсан/ болон тэдгээрийн төрөл зэргийг бичнэ/;

4.3.3. “Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн” /Үүнд: холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ/;

4.3.4. “Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал” /Үүнд: хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ/;

4.3.5. “Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, туслалцаа, хөнгөлөлт” /Үүнд: тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ, хандив, туслалцаа, хөнгөлөлтийг мэдүүлнэ/;

Тайлбар: Энэ журамд заасан “байсан” гэдэг хугацаанд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу сүүлийн хоёр жилийн хугацааг хамааруулж ойлгоно.

4.3.6. “Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал” /Үүнд: тухайн жилд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бичнэ/;

4.3.7. Мэдүүлэг гаргагч албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдэж гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Хөрөнгө, орлогыг дараах байдлаар мэдүүлнэ:

4.4.1. Орлого хэсэгт:

-“үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”;

-“шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого” /Үүнд: албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал хамаарна/;

-“үйл ажиллагааны орлого” /Үүнд: үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого хамаарна/;

-“хөрөнгийн орлого” /Үүнд: түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого хамаарна/;

-“хөрөнгө борлуулсны орлого” /Үүнд: хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого хамаарна/;

-“хандивын орлого” /Үүнд: бусдаас авсан мөнгөн хандив, тусламж хамаарна/;

-бусад орлого /Үүнд: шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого хамаарна/.

4.4.2. Хөрөнгө, зээл хэсэгт:

-“Орон сууц, барилга, байгууламж” /Үүнд: хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр, гэр зэргийг мэдүүлнэ. “Хийц, талбай” баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээг, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс орон, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ/;

-“Тээврийн хэрэгсэл” /Үүнд: автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ/;

-“Мал, аж ахуй” /Үүнд: таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлээр үржүүлж байгаа гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ/;

-“Газар” /Үүнд: мэдүүлэг гаргагчийн болон түүний гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшлийн болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ/;

-“Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл” /Үүнд:

хөрөнгийн нэр, үнэлгээ, эзэмшигчийн нэр, эх үүсвэрийн тайлбарыг мэдүүлнэ/;

-“Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картын дансны үлдэгдэл” /Үүнд: гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдлийг мэдүүлнэ. Гадаад валютыг тухайн жилийн эцсийн Монголбанкны ханшаар төгрөгт хөрвүүлэн дүнг бичнэ/;

-“Авлага” /Үүнд: хувь хүн, хуулийн этгээдээс авах бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, хүү, тайлбарыг тодорхой бичнэ/;

-“Зээл” /Үүнд: өөрийн болон гэр бүлийн гишүүдийн зээлийн талаарх мэдээллийг мэдүүлэх бөгөөд бусдаас зээлсэн бэлэн мөнгө, хөрөнгийн дүн, хугацаа, зээл, зээлийн хүүгийн дүн, зориулалтыг бичнэ/;

-“Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт” /Үүнд: өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын

хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ/;

-“Эрх, патент, тусгай зөвшөөрөл” /Үүнд: өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ/.

## Б. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж, баталгааны маягтаар бүртгүүлэх тухай

### 1. Цахим системд нэвтрэх

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг **https://meduuleg.iaac.mn** цахим хаягаар орж, мэдүүлнэ.



## 2. ХАСХОМ-ийн эрхийг үүсгэх

Мэдүүлэг гаргагчийн эрхийг цахим системд тухайн байгууллагын мэдүүлгийг хүлээн авч бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаас үүсгэнэ.

а. Цахим системд анх удаа бүртгэх бол мэдүүлэг гаргагчийг үндсэн мэдээлэл /овог, нэр, регистрийн дугаар, и-мэйл хаяг, байгууллага, албан тушаалын нэр, мэдүүлэг гаргах үндэслэл, тухайн албан тушаалд томилогдсон огноо, ХАСХОМ мэдүүлсэн он г.м/-ийг ЭБАТ-аас бүртгэнэ.

б. Урьд нь цахим системд ХАСХОМ мэдүүлж байсан бол өмнөх байгууллагын ЭБАТ-аас хасалт хийлгэн, шинээр томилогдсон байгууллага руу “Шилжүүлэн татах” үйлдлийг хийлгэж эрхийг үүсгэнэ.

## 3. Нууц үг илгээх болон сэргээх

Цахим системд нууц үгийг илгээх болон сэргээхэд дараах зарчмыг баримтална.

а. Мэдүүлэг гаргагчийг шинээр бүртгэхэд цахимд бүртгүүлсэн и-мэйл хаягаар нууц үг доорх байдлаар ирнэ.




**ХАСХОМ бүрдүүлэлтийн програмд нэвтрэх таны нууц үг w0eiBSYMGt болж өөрчлөгдлөө. Та 24 цагийн дотор нэвтэрч нууц үгээ солино уу. https://meduuleg.iaac.mn Мэдүүлэг авч дуусах хуулийн хугацаа 2 сарын 15.**

б. Мэдүүлэг гаргагч Та цахим системд нэвтрэх нууц үгээ мартсан бол “нууц үг сэргээх холбоос”-ыг дарж холбогдох үйлдлийг хийснээр “нууц үг”-ээ шинээр авч болно.

в. Мэдүүлэг гаргагч Та цахим системд нэвтрэх нэр буюу и-мэйл хаягаа өөрчлөх тохиолдолд байгууллагынхаа ЭБАТ-д хандаж солиулна.







## 4. Нууц үг солих

Мэдүүлэг гаргагч цахим системд нэвтрэх өөрийн нууц үгийг солих бол




Мэдүүлэг гаргагчийн нэрийн өмнөх хүний лого дээр дарахад гарч ирэх солих нууц үгийг оруулан солино.




## 5. ХАСХОМ мэдүүлэх

Мэдүүлэг гаргагч өөрийн ХАСХОМ-ийг мэдүүлэхдээ нүүр хуудасны жагсаалтаас баталгаажуулаагүй мэдүүлгийн “Засварлах” товч руу нэвтэрч мэдүүлнэ.



ХАСХОМ жагсаалт

| | Он | Байгууллага | Албан тушаал | Мэдүүлсэн огноо | Баталгаажуулсан огноо | Төлөв | Үйлдэл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2017 | Удирдах байгууллага АААА | Улсын байцаагч | 2018-01-06 | | | |

**Үйлдэл:**

Баталгаажуулалт хийгээгүй улаан өнгийн “**X**” хэлбэртэй байвал мэдүүлгийг засварлах эрхтэй юм.






**Дэлгэрэнгүй**



**Засварлах**

## 6. Баталгаажуулах

Мэдүүлэг гаргагч ХАСХОМ-ийг мэдүүлж дууссан бол жагсаалтын дэлгэрэнгүй ➔ товчийг сонгож дарахад “дэлгэрэнгүй хуудас” гарч ирнэ.



Мэдүүлэгчийн мэдээлэл

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Эцэг/эх/-ийн нэр: | Энхээ | Нэр: | Батдоржы | Регистрийн дугаар: | ЧЗ86061464 |
| Байгууллага: | Удирдах байгууллага АААА | Албан тушаал: | Улсын байцаагч | | |

« Мэдүүлэг гаргагч | Гэр бүлийн байдал ... | Хамаарал бүхий этгээд | Нэгдмэл сонирхолтой этгээд | Гишүүнчлэл, ... »

1.1 Мэдүүлэг гаргагч

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ургийн овог | Боржигон | Эцэг эхийн нэр | Энхээ | Өөрийн нэр | Батдоржы |
| Регистрийн дугаар | ЧЗ86061464 | Гар утас | 99124454 | Имэйл хаяг | enkhee@yahoo.com |
| Оршин суугаа газрын хаяг | Монгол, Улаанбаатар, Баянгол дүүрэг 2-р хороолол 2-р хороо, 50А байр 4 тоот | Ажлын утас | | | |
| | | Гэрийн утас | | | |
| Боловсрол, мэргэжил | Бакалавр, инженер | Байгууллагын нэр | Удирдах байгууллага АААА | | |
| Төрсөн газар | Монгол, Дорнод Дашбалбар сум, төрөх газар | Газар, хэлтэс, тасаг, алба | 11-р Байгаль орчны газар | | |
| Үндсэн харьяа | Монгол, Улаанбаатар, Баянзүрх дүүрэг | Албан тушаал | Улсын байцаагч | | |
| Сүүлийн хоёр жил ажилласан байгууллага, албан тушаал | | | | | |
| ХАСХОМ гаргасан шалтгаан | Шинэчлэн гаргасан | Тухайн албан тушаалд томилогдсон, сонгогдсон огноо | | 2014-03-03 | |




**“ХАСХОМ харах”** товчийг дарахад, мэдүүлэг PDF файл хэлбэрээр гарч ирнэ.




Үүний дараа мэдүүлэг гаргагч Та дэлгэрэнгүй хуудасны доод хэсэгт харагдах **“Баталгаажуулах”** товчийг дарснаар мэдүүлгээ баталгаажуулах ба **“Баталгааны маягт”** гэсэн товч гарах бөгөөд түүнийг дарж уг маягтыг татаж аван шалгаад, хэвлэж, гарын үсгээ зурж, байгууллагынхаа ЭБАТ-д хүлээлгэн өгч, мөн “ХАСХОМ хүлээн авсан бүртгэл”-д гарын үсгээ зурна.

Хэрвээ **“Баталгаажуулах”** товч дээр дарахад баталгаажуулалт хийгдэхгүй анхааруулга өгөөд байвал таны мэдүүлгийн “Орлого” хэсэг хоосон буюу бөглөгдөөгүй болохыг цахим системээс анхааруулж байгаа юм. */Загвар жишээ №1/*

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтын "А"

# БАТАЛГААНЫ МАЯГТ

/Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим хэлбэрээр мэдүүлсэн тухай/

Дугаар .......... ...... он ...... сар ......

| | |
|---|---|
| Удирдах байгууллага АААА<br>/Байгууллагын нэр/ | Энхээ Батдорж<br>/Эцэг/эх/-ийн нэр, нэр/ |
| 11-р Байгаль орчны газар<br>/Салбар, нэгжийн нэр/ | ЧЗ86061464<br>/Регистрийн дугаар/ |
| Улсын байцаагч<br>/Албан тушаал/ | 2014-03-03<br>/Албан тушаалд томилогдсон огноо, шийдвэрийн дугаар/ |

enkhee@yahoo.com
(https://meduuleg.iaac.mn/ цахим системд бүртгэгдсэн имэйл хаяг)

ХАСХОМ-ийг мэдүүлэх болсон үндэслэлийг сонгож тэмдэглэнэ үү.

- [ ] Томилогдсон, сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор гаргасан
- [√] Шинэчлэн гаргасан тайлант он ......2017
- [ ] Хөрөнгө, орлогод орсон их хэмжээний өөрчлөлт

ХАСХОМ-ийг мэдүүлэх эрхийг цахим системд үүсгэсэн огноо: 2018-01-03
ХАСХОМ-ийн баталгааны маягтыг хүлээн авч,
цахим системд баталгаажуулсан огноо:..........2018-01-17..........

.......Энхээ....... /эцэг/эх/-ийн нэр/ .......Батдорж....... /нэр/ миний бие Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 10.3, 10.4 дэх хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.3 дахь хэсэгт заасны дагуу ..13.. хуудас бүхий ХАСХОМ-ийг Авлигатай тэмцэх газрын (https://meduuleg.iaac.mn) цахим системд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдүүлснээ баталж байна.ХАСХОМ мэдүүлэхтэй холбоотой үүргээ зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Баталгаа гаргасан,
Мэдүүлэг гаргагч:

| | |
|---|---|
| Энхээ Батдорж<br>/Эцэг/эх-ийн нэр, нэр/ | /Гарын үсэг/ |

Баталгааны маягтыг хүлээж авсан,
Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах
эрх бүхий албан тушаалтан:

Хуулийн зөвлөх
/Албан тушаал/

| | |
|---|---|
| Ц.Батдэлгэр<br>/Эцэг/эх-ийн нэр, нэр/ | /Гарын үсэг/ |

2018 оны 01 сарын 17 өдөр

**ЗАГВАР ЖИШЭЭ №1**

*УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны*
*2012 оны 05-р тогтоолын 2-р хавсралт*

# АЛБАН ТУШААЛТНЫ 2017 ОНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

## Нэг. Мэдүүлэг гаргагч, түүний гэр бүлийн байдал:

| 1.1. Мэдүүлэг гаргагч | | |
|---|---|---|
| Ургийн овог: **Боржигон** Эцэг/эхийн нэр: **Дорж** | Нэр: **Болдбаяр** | |
| Регистрийн дугаар: А Ю 7 1 1 1 1 6 7 0 | Иргэний үнэмлэхийн дугаар: | |
| Оршин суугаа газрын хаяг: **БГД, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот** | Гар утас:**9999-9999**<br>Ажлын утас:**7011-2468**<br>Гэрийн утас:**7011-2469** | Цахим шуудангийн хаяг: **Bayar_99@gmail.com** |
| Боловсрол, мэргэжил:**Дээд, эрх зүйч** | Байгууллагын нэр: **Байгаль орчин, ногоон хөгжлийн яам** | |
| Төрсөн газар: **Архангай, Эрдэнэбулган сум, эмнэлэг** | Газар, хэлтэс, тасаг, алба: **Төрийн захиргаа, удирдлагын газар** | |
| Үндсэн харьяа: **Улаанбаатар хот, Баянгол дүүрэг** | Албан тушаал: **Ахлах мэргэжилтэн** | |
| Сүүлийн хоёр жил ажилласан байгууллага, албан тушаал:<br>**Авто замын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжилтэн** | | |
| Мэдүүлэг гаргах үндэслэл: √ тэмдэглэгээ хийнэ.<br>Шинээр томилогдсон, Сонгогдсон [ ]<br>Шинэчлэн гаргасан [√]<br>Их хэмжээний өөрчлөлт [ ] | Тухайн албан тушаалд томилогдсон, сонгогдсон огноо:<br>**2017** он **05** сар **15** өдөр | |

1.2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

| Гэр бүлийн байдал | Эцэг /эх/-ийн нэр, нэр | Регистрийн дугаар | Төрсөн газар, үндсэн харьяа | Эрхэлж байгаа ажил, албан тушаал | Ажиллаж байгаа байгууллага, сурч байгаа сургууль, оршин суугаа газрын хаяг |
|---|---|---|---|---|---|
| Эхнэр, нөхөр, хамтран амьдрагч | Очирбатын Энхцэцэг | Ш372060120 | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1 дүгээр төрөх, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг | "Улам-Ундрах" ХХК-ийн ерөнхий захирал | Ажлын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Маргад центр 545 тоот. Гэрийн хаяг: Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот. |
| Хүүхэд | Баярын Тэмүүлэн | УХ94041210 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв | ОХУ-ын Нисэхийн дээд сургуульд оюутан | Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот. |
| | Баярын Хүслэн | УХ06291020 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв | Баянгол дүүргийн 13-р дунд сургуульд сурагч | Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот. |
| Эцэг | -- | -- | -- | -- | -- |
| Эх | -- | -- | -- | -- | -- |

*Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.*

## Хоёр. Хувийн ашиг сонирхол

2.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд

| Эцэг /эх/-ийн нэр, нэр | Ямар хамааралтай болох | Ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал | Бизнес, үйл ажиллагааны чиглэл | Төрсөн газар, үндсэн харьяа |
|---|---|---|---|---|
| Гомбосүрэнгийн Батцэцэг | Эх | Өндөр насны тэтгэвэрт | -- | Завхан аймаг, Тосонцэнгэл сум. Архангай аймаг, Эрдэнэбулган сум. |
| Гаадангын Очирбат | Хадам эцэг | “ААА” ХХК-ийн ерөнхий захирал | Барилга, зам гүүр | Булган аймаг, Булган сум. УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Эрдэнэбатын Цэцэгмаа | Хадам эх | Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж байсан. 2016 онд өндөр насны тэтгэвэрт гарсан. | -- | Төв аймаг, Эрдэнэсант сум. УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Доржийн Болдсайхан | Ах | Оюуны өмчийн газарт мэргэжилтэн | Төрийн байгууллага | Архангай аймаг, Эрдэнэбулган сум. УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Доржийн Баяртүвшин | Дүү | 2014-2016 онд Соёл урлагийн хороонд мэргэжилтнээр ажиллаж байсан, одоогоор ажилгүй. | -- | Архангай аймаг, Эрдэнэбулган сум. УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Очирбатын Гэрэл | Эхнэрийн эгч | Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж амьдардаг. | БНСУ-д оёдлын үйлдвэрт ажилладаг. | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Очирбатын Бат | Эхнэрийн дүү | МУИС-н Хууль зүйн сургуулийн 3-р курсын оюутан. | Боловсрол | УБ хот, Баянзүрх дүүрэг. УБ хот, Хан-Уул дүүрэг |

*Тайлбар: Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг бичнэ.*

## 2.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

| **Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр** | **Ямар харилцаатай /байсан/ болох** /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/ | **Үйл ажиллагааны чиглэл, зорилго** | **Байгууллага. ажил, албан тушаал /**Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл**/** | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| “Улам-Ундрах” ХХК | Хувь эзэмшигч, үүсгэн байгуулагч | Гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэл | -- | 2006 онд эхнэрийн хамтаар үүсгэн байгуулсан. |
| О.Бат | Эхнэрийн дүү | Автомашины худалдаа | Япон улсаас хамтарч автомашин импортоор оруулж ирж борлуулж ашиг олдог. | 2010 оноос эхлэн одоог хүртэл хамтарч ажиллаж байна. |
| Д.Чулуун | Найз | Жимс, хүнсний ногоо тариалах | Өлзийт хороололд хүнсний ногоо, жимс жимсгэнэ тарьж борлуулдаг. | 2008 оноос эхлэн одоог хүртэл хамтарч ажиллаж байна. |

*Тайлбар: Нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ.*

**2.3. Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн**

| № | Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох | Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох | Үйл ажиллагааны чиглэл, зорилго | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Улаанбаатар хот дахь Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутгийн зөвлөл | Гишүүн | Орон нутгийг хөгжүүлэх | 2010 онд зөвлөлийн гишүүн болсон. |
| 2 | Монголын Хөл бөмбөгийн холбоо | Удирдах зөвлөлийн гишүүн | Спортыг хөгжүүлэх | 2015 оноос удирдах зөвлөлийн гишүүн болсон. |

*Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.*

**2.4. Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал**

| № | Хувь хүн, хуулийн этгээдийн нэр | Үйл ажиллагааны чиглэл | Төлөөллийг хаана, хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Төрсөн ах Д.Болдсайхан | -- | 2017 онд төрсөн ах Д.Болдсайханы өмчлөлийн орон сууцыг худалдан борлуулахад итгэмжлэлээр төлөөлсөн | Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Шинэ өглөө хотхоны 503 тоот 3 өрөө орон сууцыг худалдсан. |

*Тайлбар: Хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ.*

**2.5. Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлал, хандив, тусламж, хөнгөлөлт**

| № | *Эх сурвалжийн нэр, хаяг* | *Бэлэг, үйлчилгээ, өв залгамжлалын төрөл* | *Хандив, тусламж, хөнгөлөлтийн зориулалт* | *Үнэлгээ /төгрөг/* | *Тайлбар* |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эцэг М.Дорж /өв залгамжлал/ | Өв залгамжлалаар Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот орон сууц | -- | 80.000.000 | Эцэг М.Доржоос өв залгамжлалаар авсан. |
| 2 | Авто тээврийн газар /тусламж/ | Бэлэн мөнгө | Орон сууцны нөхцөл сайжруулах | 2 000 000 | Байгууллагаас 2017 онд орон сууцны нөхцөл сайжруулах |
| | Нийт дүн | | | 82 000 000 | |

*Тайлбар: Тухайн албан тушаалтны нэг сарын цалингаас дээш хэмжээний бэлэг, үйлчилгээ авсныг бичнэ. Хууль ёсны өв залгамжлалаар хүлээн авсан буюу авах хөрөнгийн талаар мэдүүлнэ.*

**2.6. Урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан байдал**

| **№** | **Мэдүүлэг, мэдэгдлийн нэр** | **Мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг хэзээ, хаана, хэнд гаргасан** /Байгууллага, албан тушаалтан/ | **Гаргах болсон шалтгаан, нөхцөл** | **Товч утга** |
|---|---|---|---|---|
| 1 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл | Авто замын газрын Хуулийн зөвлөх Д.Намсрайжавт 2017.06.09 | Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахдаа гаргасан. | Авто замын газраас зарласан тендерт үнэлгээний хорооны гишүүнээр оролцохдоо ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн. |
| 2 | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг | Байгаль орчин, ногоон хөгжлийн яаманд 2017.05.15-ны өдөр гаргасан | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан. | Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргасан. |

*Тайлбар: Тухайн жилд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшихдээ гаргасан урьдчилсан мэдүүлэг, бусад мэдэгдэл, тайлбар гаргасан тухай бичнэ.*

***2.7. Албан тушаалын бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэгтээ хамааралгүй байдлаар ашиглахгүйг мэдэгдье.***

***Гарын үсэг*** ***Д.Болдбаяр***

# Гурав. Хөрөнгө, орлого:

**3.1. Орлого /төгрөгөөр/**

| № | Орлогын төрөл | Орлогын дүн | | Орлогын эх үүсвэр |
|---|---|---|---|---|
| | | өөрийн | гэр бүлийн гишүүний | |
| 1 | Үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 9 024 856 | 15 650 273 | Тухайн жилд авсан өөрийн болон эхнэрийн нийт цалин хөлс |
| 2 | Шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого/ албан байгууллага болон бусад хуулийн этгээд, хувь хүнээс олгосон шагнал, урамшуулал/ | 720 850 | - | Үр дүнгийн гэрээний урамшуулал болон Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулсан шагналын орлого |
| 3 | Үйл ажиллагааны орлого / үндсэн ажлаас гадуур ажиллаж олсон орлого, хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсний орлого/ | 8 250 000 | - | Төмс болон чацаргана тариалж, борлуулсаны орлого |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Хөрөнгийн орлого /түрээс, эрхийн шимтгэл, ногдол ашиг, хүүгийн орлого, хөрөнгө бусдад ашиглуулсны орлого/ | 2 234 561 | - | Өөрийн, эхнэрийн болон хүүхдүүдийн хугацаатай, хугацаагүй хадгаламж дахь хүүгийн орлого |
| | | - | 7 200 000 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо, Өнөр хотхоны 10-р байр, 65 тоот, 34м$^2$ талбайтай 1 өрөө байрыг иргэн Б.Бадамтай түрээсийн гэрээ байгуулж, хөлслүүлсэн түрээсийн орлого |
| | | 15 000 000 | 15 000 000 | “Улам-Ундрах” ХХК-ийн 2017 оны ногдол ашиг |
| 5 | Хөрөнгө борлуулсны орлого /Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, хувьцаа борлуулсны орлого/ | 300 000 | - | 2017.08.09-нд “BBB” ХК-ийн 500 ш хувьцааг “УЛС” ХК-д худалдан борлуулсны орлого |
| | | - | 35 265 000 | Япон улсаас оруулж ирсэн 2017.02.25-нд иргэн Л.Доржид 11,2 сая төгрөгөөр Ниссан Тийда автомашиныг, 2017.05.03-нд иргэн А.Сүхбатад 13,6 сая төгрөгөөр Тоёота Гранд Марк II автомашиныг, 2017.05.03-нд иргэн У.Ундрахт 10,5 сая төгрөгөөр Тоёота Витз маркийн (номергүй) автомашиныг тус тус худалдаж борлуулсан. |
| | | 3 600 000 | - | 2017.09-р сард Архангай аймгийн Ихтамир сумын иргэн Х.Дамбад 30 толгой хонь худалдсан. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | Хандивын орлого /бусдаас авсан мөнгөн хандив, тусламж/ | 2 000 000 | - | Орон сууцны нөхцөл сайжруулахад дэмжлэг үзүүлж байгууллагаас 2017 онд олгосон мөнгөн тусламж |
| 7 | Бусад орлого /шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, бүтээгдэхүүний ашигтай загвар зохион бүтээх, спорт, урлагийн тоглолт зохион байгуулах, тэдгээрт оролцох замаар олсон орлого, тэдгээртэй адилтгах бусад орлого, шагнал, төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого, төрөөс олгож байгаа бүх төрлийн мөнгөн тэтгэмжийн орлого / | - | 240 000 | 2017 онд улсаас олгосон хүүхдийн мөнгө |
| 8 | **Нийт дүн** | **41 130 267** | **73 235 237** | |

*Тайлбар: Тайлант хугацаанд олсон орлогыг бичнэ.*

## 3.2. Хөрөнгө, зээл

¤ Орон сууц, барилга, байгууламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

**3.2.1. Орон сууц, барилга, байгууламж**

| № | Орон сууц, барилга, байгууламжийн төрөл | Хийц, талбай | Байршил /хаяг/ | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Бүртгэлийн гэрчилгээний дугаар | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нийтийн орон сууц | Угсармал, 60 м2, 3 өрөө | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны 251 тоот | 80 000 000 | Ү- 2204689721 | Эцэг М.Доржоос өвлөгдсөн. Өмчлөгч Д.Болдбаяр |
| 2 | Авто гараж | Тоосгон, 12 м2 | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 9А байрны дэргэд | 10 000 000 | Ү- 2204689729 | 2005 онд 3 сая төгрөгөөр худалдаж авсан. Хьюндэй Соната II маркийн машин зарсан орлогоор авсан. |
| 3 | Зуслангийн байр | Палкан, 60 м2, мансардтай, 2 өрөө | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан | 25 000 000 | Ү- 2304680698 | 2007-2010 онд 15 сая төгрөгийн өртөгтэйгээр өөрсдөө барьсан. Тухайн үед банкны 10 сая төгрөгийн зээл авсан, үлдсэн мөнгийг гэр бүлийн гишүүдийн цалин, хуримтлал, компаний ногдол ашгийн орлогоор бий болгосон. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Нийтийн орон сууц | Төмөр бетонон цутгамал, 34 м2, 1 өрөө | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Өнөр хотхоны 10 дугаар байрны 65 тоот | 40 000 000 | Ү- 2203512689 | 2011 онд 40 сая төгрөгөөр худалдаж авсан. Эх үүсвэр нь Орон сууц санхүүжилтийн корпорацаас 35 сая төгрөг. Үлдсэн 5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор бий болгосон. Эхнэр хадам эцэг, эхийн дундын өмчлөл. |
| 5 | Авто зогсоол | 15 м2 | Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Өнөр хотхоны 10 дугаар байрны зоорийн давхарт 15 тоот зогсоол | 14 000 000 | Ү- 22016582568 | Японоос оруулж ирсэн машин зарсан орлогоор 2010 онд 10 сая төгрөгөөр худалдаж авсан. |
| **Нийт дүн** | | | **159 000 000** | | | |

*Тайлбар: "Орон сууц, барилга, байгууламжийн төрөл" хэсэгт хувийн болон нийтийн орон сууц, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга, авто зогсоол, гараж, зуслангийн байр, гэр зэргийг мэдүүлнэ. "Хийц, талбай" баганад тухайн барилга байгууламжийн хийц, өрөөний тоо, талбайн хэмжээ, зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ. Гадаад улс, чөлөөт бүсэд байгаа орон сууц, барилга, байгууламжийг мэдүүлнэ.*

¤ Тээврийн хэрэгсэл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

**3.2.2. Тээврийн хэрэгсэл**

| № | Тээврийн хэрэгслийн төрөл, үйлдвэрлэсэн он | Тоо, ширхэг | Гэрчилгээ, улсын дугаар, эзэмшигчийн нэр | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тоёота Клюгер, 2004 онд үйлдвэрлэгдсэн | 1 ш | АЯ123456, УНП 12-34, Д.Болдбаяр | 17 000 000 | 2010 онд 15 саятөгрөгөөр худалдаж авсан. Худалдаа хөгжлийн банкны хадгаламжаас 2 сая төгрөг, “Улам- Ундрах” ХХК-ын ногдол ашгаас 5 сая төгрөг, урьд нь хэрэглэж байсан Гранд Марк II маркийн УБӨ 23-45 дугаартай машиныг борлуулсан 8 сая төгрөгөөр эх үүсвэрийг бий болгосон. |
| 2 | Тоёота Приус, 2002 онд үйлдвэрлэгдсэн | 1 ш | АЯ654321, УБП 34-56, О.Энхцэцэг | 6 000 000 | 2009 онд 8 сая төгрөгөөр хадам эцэг, эхээс эхнэр О.Энхцэцэгт худалдаж авч өгсөн. |
| Нийт дүн | | | | 23 000 000 | |

*Тайлбар: “Тээврийн хэрэгсэл” хэсэгт автомашин, өөрөө явагч хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц, бусад техник, тоног төхөөрөмжийг мэдүүлнэ. Зах зээлийн үнэлгээг мэдүүлэг гаргах үеийн зах зээлийн ханшаар үнэлж бичнэ.*

¤ Мал, аж ахуй байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх

**3.2.3 Мал, аж ахуй**

| № | Төрөл | Тоо, толгой | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар | Байршил |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хонь | 126 | 11 340 000 | Өвөө Н.Мягмараас 2000 онд тасалж өгсөн 20 хонь, төлөөр өссөн | Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг |
| 2 | Ямаа | 85 | 7 650 000 | Өвөө Н.Мягмараас 2000 онд тасалж өгсөн 20 ямаа, төлөөр өссөн | Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг |
| 3 | Адуу | 19 | 5 700 000 | Аав М.Доржоос 2005 онд 5 адуу тасалж өгсөн, 2007 онд Хэнтий аймгаас 3 унагатай гүүг 3 сая төгрөгийн хуримтлалын орлогоор худалдаж авсан, төлөөр өссөн. | Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг |
| 4 | Хурдан удмын адуу | 5 | 5 000 000 | Найз нөхдөөс бэлэглэсэн. | Архангай аймгийн Их тамир суманд нагац ах М.Рагчаагийн байдаг |
| | Нийт дүн | | 29 690 000 | | |

*Тайлбар: “Мал, аж ахуй” хэсэгт таван хошуу малаас гадна туслах аж ахуйн чиглэлээр үржүүлж байгаа гахай, тахиа, бусад тэжээвэр амьтдыг мэдүүлнэ.*

¤ Газар байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

**3.2.4 Газар**

| № | Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дугаар, он, сар, өдөр | Төрөл, хэмжээ | Байршил /бүс нутаг/, хаяг | Зах зээлийн үнэлгээ /төгрөг/ | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | ГД:987654, 2004.10.24-ны өдрийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын 358дугаартай захирамжаар | Эзэмших эрхтэй, 0,04 га | Сүхбаатар дүүргийн 15 дугаар хороо, Шарга морьт зуслан | -- | Хуулийн дагуу улсаас үнэгүй авсан. |
| 2 | ГД:123456, 2008.12.19-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын 147 дугаартай захирамжаар | Өмчлөх эрхтэй, 0,07 га | Сонгино-Хайрхан дүүргийн 20 дугаар хороо, Тахилтын аманд | 4 000 000 | 2008 онд цалин, хуримтлалын орлогоор 500000 төгрөгөөр худалдаж авсан. |
| 3 | 2006.10.24-ны өдрийн Баянгол дүүргийн Засаг даргын 322 дугаартай захирамжаар | Ашиглах эрхтэй, 12м2 | Баянгол дүүргийн 5-р хороо 10-р хороолол 9А байрны дэргэд | -- | Гэрээгээр түр ашиглаж байгаа |
| Нийт дүн | | | | 4 000 000 | |

*Тайлбар: Мэдүүлэг гаргагчийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа болон ашиглаж байгаа газрыг мэдүүлнэ.*

¤ Үнэт эдлэл, урлагийн бүтээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

**3.2.5 Үнэт эдлэл, урлаг, түүхийн үнэт зүйл**

| № | Хөрөнгийн нэр | Үнэлгээ /төгрөг/ | Эзэмшигчийн нэр | Эх үүсвэрийн болон бусад тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Шүрэн толгойтой халтар манан хөөрөг | 20 000 000 | Д.Болдбаяр | Өвөө Н.Мягмараас 2003 онд өвлөж авсан, өөрийн эзэмшилд хэрэглэдэг. |
| 2 | Мөнгөн тоногтой хуучны эмээл хазаар | 5 000 000 | Б.Тэмүүлэн | Эцэг М.Доржоос хүү Б.Тэмүүлэнд онд өвлөгдсөн. |
| | Нийт дүн | 25 000 000 | | |

¤ Хадгаламж байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

**3.2.6 Хадгаламж, бэлэн мөнгө, хувийн харилцах болон төлбөрийн данс, картны үлдэгдэл**

| № | Банк, санхүүгийн байгууллагын нэр | Дүн /төгрөг/ | Эзэмшигчийн нэр | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Худалдаа хөгжлийн банкны хугацаатай хадгаламж | 26 657 500 | О.Энхцэцэг | 2005 онд 3 сая төгрөгөөр хугацаагүй хадгаламжийн данс нээлгэсэн. Цалин, хуримтлалын орлого, хөрөнгө борлуулсны орлого, “Улам-Ундрах” ХХК-ийн ногдол ашгийг хадгалуулсан мөнгө. Дансны дугаар: 4080462018 |
| 2 | Худалдаа хөгжлийн банкны цалингийн карт | 237 000 | Д.Болдбаяр | Цалингийн орлого. Дансны дугаар: 4512748912 |
| 3 | Хаан банк, хувийн харилцах данс | 2 345 000 | О.Энхцэцэг | Үйл ажиллагааны орлого, өдөр тутмын гүйлгээ хийгддэг. Дансны дугаар: 5074135496 |
| 4 | Бэлэн мөнгө | 680 000 | О.Энхцэцэг, Д.Болдбаяр | Цалин, үйл ажиллагааны орлогын 2017.12.31-ны өдрийн үлдэгдэл дүн. |
| | Нийт дүн | 29 899 500 | | |

*Тайлбар: Энэ хэсэгт гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагад байгаа бүх төрлийн данс, картны үлдэгдлийг мэдүүлнэ.*

¤ Авлага байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 3.2.7 Авлага | | | | |
|---|---|---|---|---|
| № | Хувь хүн, хуулийн этгээдийн нэр | Дүн /төгрөг/ | Хугацаа, хүү | Тайлбар |
| -- | -- | -- | -- | -- |
| | Нийт дүн | | | |

¤ Зээл байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 3.2.8 Зээл | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| № | Зээлдүүлэгчийн нэр, хаяг | Анх авсан зээлийн хэмжээ /төгрөг/ | Тухайн жилд зээл, зээлийн хүүд төлсөн дүн / төгрөг/ | Зээл авсан, болон төлж дуусах огноо | Зориулалт | Зээлийн барьцаа, батлан даагч |
| 1 | Орон сууц санхүүжилтийн корпораци | 35 000 000 | 4 236 890 | 2011.07.20 - 2021.07.20 | Орон сууц худалдан авах | Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 5 дугаар хороо, Өнөр хотхоны 10 дугаар байрны 65 тоот |
| | Нийт дүн | 35 000 000 | | | | |

*Тайлбар: Энэ хэсэгт өөрийн болон гэр бүлийн гишүүдийн авсан зээлийн талаарх мэдээллийг мэдүүлнэ.*

¤ Хөрөнгө оруулалт байхгүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

3.2.9 Компани, нөхөрлөл, хоршоонд оруулсан хөрөнгө оруулалт

| № | Хуулийн этгээдийн нэр, хэлбэр | Хувьцааны тоо | Нэгж хувьцааны үнэ /төгрөг/ | Хувьцааг худалдаж авсан үнэ /төгрөг/ | Хуулийн этгээдийн нийт дүрмийн сан /төгрөг/ | Ногдол хувь | Эх үүсвэрийн тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | “Улам-Ундрах” ХХК | 1000 ш | - | - | 1 000 000 | 100% | 2006 онд эхнэрийн хамт үүсгэн байгуулсан. О.Энхцэцэг 50 хувийг, Д.Болдбаяр 50 хувийг тус тус эзэмшдэг. Гадаад, дотоод худалдаа, хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг. |
| 2 | “Их дэлгүүр” ХК | 148 ш | 568 | - | - | - | 1991 онд цэнхэр тасалбараар улсаас үнэгүй өгсөн, өөрийн нэр дээр бүртгэлтэй |
| | Нийт дүн | | | | 1 000 000 | | |

*Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн үүсгэн байгуулсан болон хувь нийлүүлсэн хуулийн этгээд, түүний толгой, охин, хараат болон салбар компани, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгийн биржээс худалдан авсан хувьцаа, бонд, бусад үнэт цаасыг мэдүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой бичнэ*

¤ Эрх, патент, тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй бол /-/ тэмдэглэгээ хийх.

| 3.2.10 Эрх, патент, тусгай зөвшөөрөл | | | | |
|---|---|---|---|---|
| № | Төрөл | Эзэмшигчийн нэр | Тусгай зөвшөөрлийг олгосон байгууллага, огноо | Тайлбар |
| 1 | Зохиогчийн эрх | Д.Болдбаяр | Оюуны өмчийн газар, 2010 он | “Ухаарлын хишиг” ном бичиж зохиогчийн эрх авсан. |

*Тайлбар: Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн өмчлөл, эзэмшилд байгаа зохиогчийн эрх, патент, тусгай зөвшөөрлийг мэдүүлнэ.*

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн: *(signature)* **/Д.Болдбаяр/**

*/гарын үсэг/* */гарын үсгийн тайлал/*

2018 оны 02 дугаар сарын 10-ны өдөр
*Огноо*

# ДОЛОО. ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ

ХАСХОМ гаргах үүрэгтэй нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн болон цаашид тухайн байгууллагын зохион байгуулалтын нэгж дотроо ажлын байрны тодорхойлолт, эрхлэх асуудлын чиг үүрэгт нь өөрчлөлт орсны улмаас шилжүүлэн болон сэлгэн томилох, туршилтын хугацаагаар, Төрийн албаны тухай хуулийн хүрээнд тухайн албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохын өмнө Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /цаашид "ХАСУМ" гэх/-ийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан маягтын дагуу гаргана.

Нэр дэвшигч нь ХАСУМ-ийн маягтыг төрийн албан хаагчийн анкетын хамт бөглөөд тухайн байгууллагын ЭБАТ-д гаргана. Байгууллагын томилох эрх бүхий удирдах албан тушаалтнаас ХАСУМ-ийг холбогдох материал /ТАХ-ийн анкет, батлагдсан ажлын байрны тодорхойлолт/-ын хамт албан бичгээр Авлигатай тэмцэх газар /Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс/-т хүргүүлнэ.

Авлигатай тэмцэх газар нь материалыг хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хянан үзэж, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар дүгнэлт гаргах бөгөөд уг дүгнэлтийг үндэслэн байгууллагын удирдлага буюу томилох эрх бүхий албан тушаалтан нь хуульд нийцүүлэн томилгоо хийнэ. /Загвар жишээ №2/

**ЗАГВАР ЖИШЭЭ № 2**

*УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны*
*2012 оны 05-р тогтоолын 3-р хавсралт*

# НИЙТИЙН АЛБАНД ТОМИЛОГДОХООР НЭР ДЭВШСЭН ЭТГЭЭДИЙН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН УРЬДЧИЛСАН МЭДҮҮЛЭГ

## 1. Мэдүүлэг гаргагчийн талаарх мэдээлэл

<table>
<tr><td>Ургийн овог: Бичээч</td><td>Эцэг/эхийн нэр:<br>Гармаа</td><td>Нэр: Сандаг</td></tr>
<tr><td>Регистрийн дугаар:<br>А | Ю | 7 | 5 | 1 | 0 | 1 | 6 | 0 | 0</td><td>Төрсөн он, сар, өдөр:<br>1975-10-16</td><td>Иргэний үнэмлэхийн дугаар:</td></tr>
<tr><td colspan="2">Төрсөн газар: Ховд аймаг, Зэрэг сум, төрөх эмнэлэг</td><td>Оршин суугаа газрын хаяг:<br><br>Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо,<br>9 дүгээр хороолол, 29/А байрны<br>27 тоот</td></tr>
<tr><td>Гар утас:9990-9990 Гэрийн утас:7011-2469<br>Цахим шуудангийн хаяг: G_San@gmail.com</td><td colspan="2">Урьд нийтийн албанд ажиллаж байсан эсэх /ямар байгууллагад/:<br>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Замын-Үүд дэх Гаалийн газар<br><br>Албан тушаал: Ахлах байцаагч</td></tr>
<tr><td colspan="3">Сүүлийн хоёр жилийн ажил эрхлэлт:<br>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Санхүүгийн хяналтын улсын байцаагч</td></tr>
<tr><td colspan="3">Нийтийн албаны аль байгууллага, албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн:<br>Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газарт ахлах мэргэжилтэн</td></tr>
<tr><td colspan="3">Нэр дэвшсэн нийтийн алба /төрийн байгууллага/, түүний салбар, нэгжийн үйл ажиллагаатай хамааралтай худалдаа, үйлдвэр, үйлчилгээ эрхэлж байсан эсэх:<br>Үгүй</td></tr>
</table>

## 2. Мэдүүлэг гаргагчийн гэр бүлийн байдал

| Гэр бүлийн байдал | Эцэг /эх/- ийн нэр, нэр | Регистрийн дугаар | Төрсөн газар, үндсэн харьяа | Эрхэлж байгаа ажил, албан тушаал | Ажиллаж байгаа байгуулага, сурчбайгаа сургууль, оршин суугаа газрын хаяг |
|---|---|---|---|---|---|
| **<u>Эхнэр</u>**, нөхөр, хамтран амьдрагч | Дондогийн Сарантуяа | Ш376060120 | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1 дүгээр төрөх, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг | “Өнөр- Арвижих” ХХК- ийн ерөнхий захирал | Ажлын хаяг: УБ хот, Баянгол дүүрэг, 4-р хороо, Алтөн дөл центр 12 тоот.<br>Гэрийн хаяг: Хан-Уул дүүрэг 3-р хороо, 9-р хороолол, 29/А байрны 27 тоот. |
| Хүүхэд | Сандагийн Баярбаатар | УХ95061219 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв | ШУТИС-ийн Мэдээллийн технологийн сургуульд оюутан | Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, 9 дүгээр хороолол, 29/А байрны 27 тоот. |
| | Сандагийн Баяржавхлан | УХ05191605 | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Эх нялхас эрдэм шинжилгээний төв | Баянгол дүүргийн 38-р дунд сургуульд сурагч | Хан-Уул дүүрэг 3 дугаар хороо, 9 дүгээр хороолол, 29/А байрны 27 тоот. |
| Эцэг | -- | -- | -- | -- | -- |
| Эх | -- | -- | -- | -- | -- |

*Тайлбар: Хамт амьдарч байгаа болон өрхийн бүртгэлд бүртгэлтэй эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, хүүхэд, эцэг, эхийг бичнэ.*

# 3. Хувийн ашиг сонирхол

**3.1. Мэдүүлэг гаргагчтай хамаарал бүхий этгээд**

| Эцэг /эх/- ийн нэр, нэр | Ямар хамааралтай болох | Ажиллаж байгаа /байсан/ байгууллага, албан тушаал | Бизнес, үйл ажиллагааны чиглэл | Төрсөн газар, үндсэн харьяа |
|---|---|---|---|---|
| Даржаагийн Доржготов | Эцэг | "ҮҮҮ" ХХК-ийн ерөнхий захирал | Харуул, хамгаалалт | Ховд аймаг, Зэрэг сум. Өвөрхангай аймаг, Арвайхээр сум. |
| Зундуйн Дондог | Хадам эцэг | Тэтгэвэрт | --- | Сэлэнгэ аймаг, Баруунбүрэн сум. УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Дашжамцийн Цэрэнханд | Хадам эх | Бага ангийн багшаар ажиллаж байсан. 2013 онд тэтгэвэрт гарсан. | --- | Булган аймаг, Хишиг-Өндөр сум. УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Гармаагийн Намсрай | Төрсөн ах | Санхүүгийн зохицуулах хороонд мэргэжилтэн | Төрийн алба | Ховд аймаг, Зэрэг сум. УБ хот, Сүхбаатар дүүрэг. |
| Гармаагийн Өнөрболд | Төрсөн дүү | Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | Төрийн алба | Өвөрхангай аймаг, Арвайхээр сум. |
| Дондогийн Туяа | Эхнэрийн эгч | Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж амьдардаг. | БНСУ-д оёдлын үйлдвэр. | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1 дүгээр төрөх, УБ хот, Баянзүрх дүүрэг. |
| Дондогийн Оюунцэцэг | Эхнэрийн дүү | МУИС-н Эдийн засгийн сургуульд оюутан. | Боловсрол | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1 дүгээр төрөх, УБ хот, Хан-Уул дүүрэг |

*Тайлбар: Нийтийн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээ, шууд болон шууд бус нөлөөлөх боломжтой байгууллагад харьяалалтай болон хамааралтай ажил эрхэлж байгаа /байсан/ өрх тусгаарласан эцэг, эх, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, эхнэр /нөхөр/, хамтран амьдрагчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүг бичнэ.*

### 3.2. Мэдүүлэг гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд

| **Ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийн нэр** | **Ямар харилцаатай /байсан/ болох** /хуулийн этгээд бол ямар хамааралтай болох/ | **Үйл ажиллагааны чиглэл, зорилго** | **Байгууллага. ажил, албан тушаал** Эрхэлж байгаа /байсан/ үйл ажиллагааны төрөл**/** | **Тайлбар** |
|---|---|---|---|---|
| “Өнөр-Арвижих” ХХК | Хувь эзэмшигч, үүсгэн байгуулагч | Тээвэр зуучлал | -- | 2009 онд эхнэрийн хамтаар үүсгэн байгуулсан. |
| У.Дамбийжанцан | Найз | -- | Япон улсаас хамтарч автомашины сэлбэг, хэрэгсэл импортоор оруулж ирж борлуулж ашиг олдог. | 2012 оноос эхлэн одоог хүртэл хамтарч ажиллаж байна. |

*Тайлбар: Нийтийн албан тушаалтантай ашгийн төлөө үйл ажиллагаагаар холбоотой хувь хүн, хуулийн этгээдийн талаар бичнэ.*

**3.3. Гишүүнчлэл, хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн**

| № | Хаана, ямар байгууллагад харьяалалтай болох | Албан тушаал, үүсгэн байгуулагч, гишүүн, дэмжигчийн аль нь болох | Үйл ажиллагааны чиглэл, зорилго | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Мэргэшсэн нягтлан бодогчдын институт | Гишүүн | Нягтлан бодогчдыг мэдлэгийг дээшлүүлэх | 2009 оноос |
| 2. | Монголын Буудлагын спортын холбоо | Удирдах зөвлөлийн гишүүн /байсан/ | Спортыг хөгжүүлэх | 2009-2015 онд гишүүнээр ажиллаж байсан. |

*Тайлбар: Холбоо, нэгдэл, хөдөлгөөн, нутгийн зөвлөлийн тэргүүн, гишүүн, нам, улс төр, олон нийтийн байгууллагын гишүүнчлэлд байсан болон байгаа талаар бичнэ.*

**3.4. Төлөөлөл хэрэгжүүлсэн байдал**

| № | Хувь хүн, хуулийн этгээдийн нэр | Үйл ажиллагааны чиглэл | Төлөөллийг хаана, хэзээ, хэрхэн хэрэгжүүлсэн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1. | Төрсөн ах Гармаагийн Намсрай | -- | 2015 онд төрсөн ах Г.Намсрайгийн өмчлөлийн газрыг худалдахад итгэмжлэлээр төлөөлсөн. | УБ хот, Хан-Уул дүүргийн Өлзийт хороололд байрлах 0,07 га газрыг худалдсан. |

*Тайлбар: Хувь хүн, хуулийн этгээдийг төлөөлөн тодорхой үйл ажиллагаа, харилцаанд оролцсон талаар бичнэ.*

**3.5. Нэр дэвшсэн нийтийн алба, байгууллагад ажилладаг, түүний эрхлэх асуудал, харьяалах нутаг дэвсгэрт байгаа хамаарал бүхий этгээд**

| № | Эцэг /эх/-ийн нэр, нэр | Эрхэлж байгаа ажил, албан тушаал | Ямар хамааралтай болох |
|---|---|---|---|
| 1. | Гармаагийн Өнөрболд | Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | Төрсөн дүү Г.Өнөрболд нь Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга бөгөөд Сангийн яамнаас аймгуудын санхүү, төрийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьдаг. |

*Тайлбар: Ямар хамааралтай болох талаар дэлгэрэнгүй тайлбарыг бичнэ.*

Жич: Энэхүү маягтад төрийн албан хаагчийн анкет, ял шийтгэлгүй эсэх талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хөрөнгө, оруулагчийн талаарх лавлагаа, бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.

Мэдүүлгийг үнэн зөв мэдүүлсэн: **/Г.Сандаг/**

*/гарын үсэг/* */гарын үсгийн тайлал/*

2017 оны 06 дугаар сарын 25-ны өдөр

*огноо*

# НАЙМ. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ ҮҮССЭН ЭСЭХ АСУУДЛААР МЭДЭГДЭЛ, ТАЙЛБАР ГАРГАХ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу албан тушаалтан захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах бөгөөд үүнийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийн 3.8-д нарийвчлан зохицуулсан. Үүнд:

- ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсч болзошгүй гэж үзвэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын түвшинд батлагдах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;
- ашиг сонирхлын зөрчилтэй буюу зөрчил үүсч болзошгүй гэж үзвэл Засгийн газар, Засгийн газрын гишүүн, яам, агентлаг, бүх шатны Засаг даргын түвшинд гарах шийдвэрийн төслийг боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах түвшинд гарах шийдвэр, гэрээ хэлцлийн төсөл боловсруулах болон шийдвэр гаргахад оролцох.

Дээр дурдсан тохиолдолд ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх талаарх мэдэгдэл, тайлбарыг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу холбогдох байгууллагын удирдлагад гаргаж, ЭБАТ бүртгэнэ.

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал үүсвэл тухайн албан тушаалтан уг нөхцөл байдалд

дээрх маягтын дагуу бичгээр тайлбарыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргана.

Хэрвээ ашиг сонирхлын зөрчил үүсч болзошгүй болон ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөл байдал бий болсон бол түүний шалтгааны талаар дурдаж, уг албан үүргийг гүйцэтгэхээс албан ёсоор татгалзах нь зүйтэй.

Эрх бүхий байгууллага болон албан тушаалтан нь сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдлийг шийдвэрлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг хянасны эцэст уг албан үүргийг өөр албан тушаалтнаар гүйцэтгүүлэх эсэх шийдвэрийг нэн даруй бичгээр гаргана.

Албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг дараах тохиолдолд зөвшөөрч болно:

- тухайн байгууллагын нэгж, эсхүл тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй, дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй;
- тухайн албан үүргийг гүйцэтгэхэд мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдах ба зөвхөн ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргасан албан тушаалтан энэ шаардлагыг хангаж байгаа бол;

Ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал болон ашиг сонирхлын зөрчил үүссэн талаар гаргасан тайлбар, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэлд эрх бүхий байгууллага, албан тушаалтан нэн даруй шийдвэр гаргаагүй бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж үзсэнд тооцно.

Ийнхүү ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэхээ илэрхийлж мэдэгдэх нь Таныг уг албан үүргийг гүйцэтгэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй эсвэл сонирхлын зөрчилгүй болохыг нотлон харуулах баримт, нөгөө талаас авлига, ашиг сонирхлын зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж байгаа хэрэг юм. */Загвар жишээ № 3, 4/*

## ЗАГВАР ЖИШЭЭ №3

*УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт*

# АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, *ЗӨРЧИЛ ҮҮССЭН* ТУХАЙ МЭДЭГДЭЛ

## Нэг. Нийтийн албан тушаалтан

| | | |
|---|---|---|
| Ургийн овог: ***Боржигон*** | Эцэг (эх)-ийн нэр: ***Балданжав*** | Нэр: ***Заяажаргал*** |
| Албан тушаал: ***Ахлах мэргэжилтэн*** | Ажиллаж байгаа байгууллага: ***Боловсрол соёл, шинжлэх ухааны яам*** | |
| Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр: ***2017.10.24*** | Байгууллагын хаяг: ***Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай, Засгийн газрын ... дугаар байр*** | |
| Албан үүргийн төрөл: ***Бараа, ажил үйлчилгээ худалдан авах, шалгаруулах*** | Тайлбар: ***БСШУСЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017.11.09-ний өдрийн А/1010 дугаар тушаалаар "Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвийн ЕБС-ийн барилгын их засварын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах" үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд гишүүнээр ажилласан.*** ***Тендерын дугаар № CC-2015/05/ НТШ-19*** | |

Сонирхлын зөрчилтэй эсэх: ***Тийм*** ☑ Үгүй ☐

## Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

## Гурав.Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

- [ ] гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

- [ ] гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:
- [x] байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

***Тендерт оролцож байгаа “Говийн хөгжил” ХХК-нд 2015-2016 онд менежерээр ажиллаж байсан.***

- [ ] Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

**Дөрөв. Баталгаажуулалт.**

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

***Боловсрол соёл, шинжлэх ухааны яамны***

***ахлах мэргэжилтэн*** ***Б.Заяажаргал***

..........................................................................................

/албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр
*огноо*

**Шийдвэрлэсэн байдал**

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх:

Тийм ☐ ***Үгүй*** ☑

Хэрэв “Тийм” бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:
***Төрийн нарийн бичгийн дарга***

**_Д.Батнайрамдал_**

...............................................................................................
/албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр
*огноо*

## ЗАГВАР ЖИШЭЭ №4

*УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт*

# АШИГ СОНИРХЛЫН *ЗӨРЧИЛГҮЙ* ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

## Нэг. Нийтийн албан тушаалтан

<table>
<tr><td>Ургийн овог:<br>Хатиган</td><td colspan="2">Эцэг (эх)-ийн нэр:<br>Намсрайжав</td><td>Нэр:<br>Батбаатар</td></tr>
<tr><td colspan="2">Албан тушаал:<br>Дарга</td><td colspan="2">Ажиллаж байгаа байгууллага:<br>Дорноговь аймгийн Замын-үүд сумын Засаг дарга</td></tr>
<tr><td colspan="2">Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр:<br>2017.01.31</td><td colspan="2">Байгууллагын хаяг:<br>Дорноговь аймгийн Замын-үүд сум, 1-р баг</td></tr>
<tr><td>Албан үүргийн төрөл:<br>“Хяналт шалгалт зохион байгуулах тухай” 2017.09.06-ны өдрийн 258 тоот захирамж гаргах</td><td colspan="3">Тайлбар:<br>Дорноговь аймгийн Замын-үүд сумын төвд байрлах согтууруулах ундаагаар үйлчилдэг, тус сумын Засаг даргын 2017.09.06-ны өдрийн 258 тоот захирамжийн хавсралтад дурдагдсан хяналт шалгалтад хамрагдах аж ахуй нэгж байгууллагуудтай ашиг сонирхлын зөрчилгүй болно.</td></tr>
</table>

Сонирхлын зөрчилтэй эсэх: Тийм ☐ ***Үгүй*** ☑

## Хоёр. Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал

Нийтийн албан тушаалтан ***Дорноговь аймгийн Замын-үүд сумын Засаг дарга Н.Батбаатар*** би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

## Гурав. Сонирхлын зөрчил үүссэн тухай

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

☐ гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

☐ гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

☐ байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

☐ Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

**Дөрөв. Баталгаажуулалт.**

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

***Дорноговь аймгийн Замын-Үүд сумын***

***Засаг дарга*** ***Н.Батбаатар***

.................................................................................................................
/албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр
*огноо*

**Шийдвэрлэсэн байдал**

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх:

Тийм ☐ Үгүй ☐

Хэрэв “Тийм” бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

..........................................................................................................

/албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

.......... он ......... сар ........... өдөр

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

| | |
|---|---|
| 2017 оны 04 дүгээр<br>сарын 13-ны өдөр | Улаанбаатар<br>хот |

## НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай 101дүгээр зүйл нэмсүгэй:

**$10^{1}$дүгээр зүйл.** Оффшор бүсэд банкны данс эзэмших, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хуулийн этгээд байгуулахтай холбогдсон хориглолт

$10^{1}$.1.Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглоно.

$10^{1}$.2.Холбогдох хуулиар тогтоосон болзол, шалгуурын дагуу сонгогддог, эсхүл сонгуулийн үр дүнд томилогддог албан

тушаалд нэр дэвшигч, түүний хамаарал бүхий этгээд нь нэр дэвшигчийг тухайн албан тушаалд нэр дэвшихэд оффшор бүсэд өөрийн нэр дээр банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол холбогдох байгууллагад урьдчилан мэдүүлэх үүрэгтэй.

$10^{1}$.3.Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийг олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан Монголбанк, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

$10^{1}$.4.Энэ хуулийн $10^{1}$.2 дахь хэсэгт заасан нэр дэвшигч албан тушаалд сонгогдсон, эсхүл томилогдсон тохиолдолд тухайн албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд банкны данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол 3 сарын дотор дараах арга хэмжээг авч, өмчийн байдалд орсон өөрчлөлт, орлогын талаар 30 хоногийн дотор Авлигатай тэмцэх газарт мэдүүлнэ:

$10^{1}$.4.1.нээлгэсэн банкны дансаа хаалгах;

$10^{1}$.4.2.банканд байршуулсан мөнгөн хөрөнгөө татах;

$10^{1}$.4.3.хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг худалдах, шилжүүлэх, татах;

$10^{1}$.4.4.хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйл ажиллагаагаа зогсоох, эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ худалдах, шилжүүлэх, дуусгавар болгох.

$10^{1}$.5.Албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд нь оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, хөдөлмөр эрхлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээ

авах, хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх хугацаанд тухайн улсын банканд данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөхөд энэ хуулийн $10^{1}$.1 дэх хэсэг хамаарахгүй. Хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гадаад улс, түүний нутаг дэвсгэрт суралцах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах зорилгоор тухайн улсын банканд данс нээлгэсэн, мөнгөн хөрөнгө байршуулсан, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчилсөн бол Авлигатай тэмцэх газарт бичгээр мэдэгдэнэ.

$10^{1}$.6.Энэ хуулийн $10^{1}$.2, $10^{1}$.4 дэх хэсэгт заасан үүргээ биелүүлсэн нь ашиг сонирхлын зөрчил үүссэн, эсхүл үүсч болзошгүйд тооцох үндэслэл болохгүй.

$10^{1}$.7.Энэ хуулийн $10^{1}$.1, $10^{1}$.2, $10^{1}$.4, $10^{1}$.5 дахь хэсэгт заасныг зөрчсөн нь албан тушаалтныг эгүүлэн татах үндэслэл болно.”

**2 дугаар зүйл.** Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.4 дэх заалтын “11,” гэсний өмнө “$10^{1}$.1, $10^{1}$.2, $10^{1}$.4, $10^{1}$.5 дахь хэсэг,” гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2017 оны 12 дугаар сарын 6-ны өдөр

Дугаар 326

Улаанбаатар хот

Жагсаалт шинэчлэн батлах тухай

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн $10^1$.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглох оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан шинэчлэн тогтоох асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2017 оны 326 дугаар тогтоолын хавсралт

## ОФФШОР БҮСЭД ХАМААРАХ ГАДААД УЛС, ТҮҮНИЙ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЖАГСААЛТ

| | Нэр (монгол хэлээр) | Нэр (англи хэлээр) |
|---|---|---|
| 1. | Ангиль | Anguilla |
| 2. | Андоррагийн Хант Улс | Andorra |
| 3. | Антигуа Барбуда | Antigua & Barbuda |
| 4. | Арабын Нэгдсэн Эмират | United Arab Emirates |
| 5. | Аруба | Aruba |
| 6. | Барбадос Улс | Barbados |
| 7. | Бахамын арлууд | Bahamas |
| 8. | Бахрейны Хаант Улс | Bahrain |
| 9. | Белиз Улс | Belize |
| 10. | Бермудын арал | Bermuda |
| 11. | Ботсвана | Botswana |
| 12. | Британийн Виржинийн арлууд | British Virgin Islands |
| 13. | Бруней | Brunei |
| 14. | Бүгд Найрамдах Вануату Улс | Vanuatu |
| 15. | Бүгд Найрамдах Кипр Улс | Cyprus |
| 16. | Бүгд Найрамдах Коста-Рика Улс | Costa Rica |
| 17. | Бүгд Найрамдах Либери Улс | Liberia |
| 18. | Бүгд Найрамдах Ливан Улс | Lebanon |
| 19. | Бүгд Найрамдах Мавритан Улс | Mauritius |
| 20. | Бүгд Найрамдах Мальта Улс | Malta |
| 21. | Бүгд Найрамдах Панам Улс | Panama |
| 22. | Бүгд Найрамдах Уругвай Улс | Uruguay |
| 23. | Гернси | Guernsey |
| 24. | Гибралтар | Gibraltar |
| 25. | Гренад Улс | Grenada |
| 26. | Доминикийн Хамтын Нөхөрлөлийн Улс | Dominica |
| 27. | Жерси | Jersey |
| 28. | Ирланд Улс | Ireland |
| 29. | Кайманы арлууд | Cayman Islands |
| 30. | Куракао | Curacao |
| 31. | Куукийн арлууд | Cook Islands |
| 32. | Лихтенштейний Вант Улс | Liechtenstein |
| 33. | Люксембург | Luxembourg |
| 34. | Макао | Macao, SAR |
| 35. | Малайз | Malaysia |
| 36. | Маршаллын арлууд | Marshall Islands |
| 37. | Монако | Monaco |

| | | |
|---|---|---|
| 38. | Монтсеррат Улс | Montserrat |
| 39. | Мэний арал | Isle of Man |
| 40. | Нидерландын Антиллийн Арлууд | Netherlands Antilles |
| 41. | Самоагийн Тусгаар улс | Independent State of Samoa |
| 42. | Сейшелийн Арлын Бүгд Найрамдах Улс | Seychelles |
| 43. | Сент-Винсент-Гренадин Улс | St. Vincent and Grenadines |
| 44. | Сент-Китс-Невисийн Холбооны Улс | St. Kitts and Nevis |
| 45. | Сент-Люси Улс | St. Lucia |
| 46. | Сингапур | Singapore |
| 47. | Тёркс-кайкосын арлууд | Turks and Caicos Islands |
| 48. | Хонконг | Hong Kong, SAR |
| 49. | Швейцар | Switzerland |

# ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ

# ТЭМДЭГЛЭЛ